



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 07 сарын 05 өдөр

Дугаар 341

Улаанбаатар хот

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2023 оны Улсын төсөв болон Ирээдүйн өв санд төвлөрүүлэх төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийн хувь хэмжээг тогтоох тухай

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5.1 дэх заалт, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.5 дахь хэсэг, Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийн цэвэр ашгийн дүнгээс Улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн хэмжээг нэгдүгээр, Ашигт малтмалын ордны тусгай зөвшөөрөл эзэмшигч төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд болон төрийн өмчит үйлдвэрийн газрын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийн цэвэр ашгийн дүнгээс Ирээдүйн өв санд төвлөрүүлэх төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийн хэмжээг 2 дугаар хавсралт ёсоор тус тус тогтоосугай.

2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2023 оны 07 дугаар сарын 05-ны
өдрийн 341 дугаар тогтоолын нэгдүгээр
хавсралт

ТӨРИЙН ӨМЧИТ БОЛОН ТӨРИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН
ЭТГЭЭДИЙН 2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН
ТЭНЦЛИЙН ЦЭВЭР АШГИЙН ДҮНГЭЭС УЛСЫН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ
НОГДОЛ АШГИЙН ХЭМЖЭЭ

Д/д	Нэр	2022 оны цэвэр ашгийн дүн /мянган төгрөг/	Төрийн өмчийн ногдол ашиг /мянган төгрөг/
1	"Монголын цахилгаан холбоо" ХК	10,700.04	5,066.47
2	"Монгол шуудан" ХК	451,283.10	148,923.42
3	"Улаанбаатар дулааны сүлжээ" ХК	2,044,316.90	613,295.06
4	"Цемент шохой" ТӨХК	11,630,695.70	5,815,347.85
5	"Мэдээлэл холбооны сүлжээ" ХХК	2,356,094.43	1,178,047.22
6	"Хөдөө аж ахуйн бирж" ХХК	1,015,792.80	507,896.40
7	"Диспетчерийн үндэсний төв" ХХК	111,324.74	55,662.37
8	"Эрчим хүчний үндэсний төв" ХХК	58,796.30	29,398.15
9	"Биокомбинат" ХХК	18,217.26	9,108.63
10	"Геологийн судалгааны төв" ТӨҮГ	460.40	230.20
11	"Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж" ТӨҮГ	1,307,291.68	653,645.84
12	"Монгол кино нэгтгэл" ТӨҮГ	52,305.68	26,152.84
13	"Барилгын хөгжлийн төв" ТӨҮГ	903,130.70	451,565.35
14	"Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ	6,841,220.08	684,122.01
15	"Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ	565,686.10	282,843.05
16	"Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар" ТӨҮГ	540,608.40	270,304.20
17	"Мэдээлэл технологийн үндэсний парк" ТӨҮГ	2,963.10	1,481.55
18	"Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа хамтын ажиллагааны төв" ТӨҮГ	8,320.70	4,160.35
19	"Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК	1,736,482.00	868,241.00
20	Төрийн банк	97,294,843.21	48,084,529.20
НИЙТ ДҮН		126,950,533.32	59,690,021.16

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2023 оны 07 дугаар сарын 05-
ны өдрийн 331 дугаар тогтоолын
хоёрдугаар хавсралт

АШИГТ МАЛТМАЛЫН ОРДЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧ ТӨРИЙН
ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭД БОЛОН ТӨРИЙН ӨМЧИЙН
ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН 2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН
ТЭНЦЛИЙН ЦЭВЭР АШГИЙН ДҮНГЭЭС ИРЭЭДҮЙН ӨВ САНД ТӨВЛӨРҮҮЛЭХ
ТӨРИЙН ӨМЧИД НОГДОХ ХУВЬЦААНЫ НОГДОЛ АШГИЙН ХЭМЖЭЭ

Д/д	Нэр	2022 оны цэвэр ашгийн дүн /мянган төгрөг/	Төрийн өмчийн ногдол ашиг /мянган төгрөг/
1	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ	831,164,091.90	415,582,045.95
2	"Монголросцветмет" ТӨҮГ	1,333,373.36	666,686.68
3	"Эрдэнэс Тавантолгой" ХК	1,110,525,487.46	135,761,740.84
НИЙТ ДҮН		1,943,022,952.72	552,010,473.47